



ДУНДГОВЬ АЙМГИЙН
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 03 сарын 21 өдөр

Дугаар А/04

Мандалговь

Зөвлөл шинэчлэн батлах тухай

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2, 29 дүгээр зүйлийн 29.2 дэх заалт, Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/114 тоот “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл байгуулах, орон тооны ажилтан ажиллуулах норматив батлах тухай” тушаалын 2 дугаар зүйлийн 2.3, 2.4, 2.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орон тооны бус зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Дарга: - Газар, газрын хэвлий, түүний баялгийн ашиглалт, нөхөн сэргээлт, хөрсний доройтол (Цөлжилт), байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хариуцсан мэргэжилтэн

Гишүүд: - Мэдээллийн сан, байгаль орчны төлөв байдал, сургалт сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн

- Биологийн төрөл зүйл, тусгай хамгаалалттай газар нутаг, судалгаа шинжилгээ хариуцсан мэргэжилтэн

2. Байгууллагын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн ажиллах журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг зөвлөлд, тухай бүр тайлагнаж ажиллахыг зөвлөлийн даргад тус тус үүрэг болгосугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Газрын даргын 2020 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн “Зөвлөл шинэчлэн батлах тухай” А/18 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА  Н.ГАНТУЛГА



Tuhsaal A

482301021